



БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 12 сарын 04 өдөр

Дугаар А/401

Улаанбаатар хот

Баянзүрх дүүргийн хэмжээнд биеийн тамир,
спортын улсын нэг удаагийн үзлэг, тооллого
явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 "а" дэд заалт, 29.2 дахь хэсэг, Статистикийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, Үндэсний статистикийн хорооны даргын 2017 оны А/186 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Биеийн тамир, спортын улсын нэг удаагийн үзлэг тооллогыг зохион байгуулах түр товчооны бүрэлдэхүүнийг хавсралтаар баталж, 2017 оны 11 дүгээр сарын 30-ны өдрөөс 2017 оны 12 дугаар сарын 20-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2. Батлагдсан маягтын дагуу үзлэг тооллогыг зохион байгуулж тооллогын дүнг эргэн танилцуулах, холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлэхийг түр товчоо /С.Сувд-Эрдэнэ/-нд даалгасугай.

3. Тооллогын ажлыг удирдамжийн дагуу зохион байгуулахыг Биеийн тамир спортын хороо /С.Эрдэнэбат/, Боловсролын хэлтэс, хороодын Засаг дарга нарт, мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллахыг Статистикийн хэлтэс /Э.Энхтунгалаг/-т тус тус үүрэг болгосугай.

4. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газар /Б.Амартүвшин/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Т.БАЯСАХ